

**Аймаг, дүүргийн мэдээлэл зүйн олимпиад
зохион байгуулахад баримтлах дэг**

1. Аймаг, дүүргийн мэдээлэл зүйн олимпиадыг эрх бүхий этгээдийн байгуулсан комисс зохион байгуулна.
2. Олимпиад явуулах лабораторийн компьютерт оролцогчдын ашиглахаар санал өгсөн программчлалын хэлний компилятор, pdf уншигч эсвэл office суулгасан байх ба үүнээс өөр программ, файлууд, ялангуяа программын эх кодуудыг цэвэрлэж компьютерын ажиллагааг шалган бэлтгэсэн байна.
3. Олимпиад эхлэхээс 20-30 минутын бүх оролцогчид суудлаа эзэлсэн байх ба компьютерын болон программуудын хэвийн ажиллагааг шалгаж, асуудал гарвал **зохион байгуулах комисст мэдэгдэж** шийдвэрлүүлсэн байна.
4. Оролцогчдыг суудалд суулгахаас өмнө тэдний **гар утас, ухаалаг цаг, флаш диск болон бусад дижитал төхөөрөмжийг** бүгдийг хураан авсан байна. Хэрэв олимпиадын явцад ямар нэг дижитал төхөөрөмж ашиглах оролдлого хийсэн эсвэл ашигласан бол **зохион байгуулах комисс нь** тухайн оролцогчийн бүх оноог 0 болгож, тэмцээнээс хасна. Энэ тухай протоколд дэлгэрэнгүйгээр тэмдэглэсэн байна.
5. Олимпиадад оролцогч нь олимпиадын үргэлжлэх хугацаанд интернэт ашиглахыг хатуу хориглоно. Хэрэв оролцогч интернэт ашиглах, хайлт хийх, и-мэйл хаягтаа хандах зэрэг зохисгүй үйлдлийн аль нэгийг эсвэл хэд хэдийг гаргасан бол **зохион байгуулах комисс нь** уг оролцогчийн бүх оноог 0 болгож, тэмцээнээс хасна. Энэ тухай протоколд дэлгэрэнгүйгээр тэмдэглэсэн байна.
6. Олимпиадад оролцогчийн үйл ажиллагааг баталгаажуулах үүснээс олимпиадын явагдах бүхий л хугацаанд оролцогч бүрийн дэлгэцийг бичих эсвэл оролцогчдын нүүрийг харуулалгүй, мөн саад болохгүй байхаар бүх оролцогч харагдаж байхаар камераар билэг хийж болно.
7. Олимпиадын ангилал бүрд нэг эсвэл хэд хэдэн хянагч багш (ажилтан) ажиллах ба оролцогч нэг бүрийн үйл ажиллагаанд тасралтгүй хяналт тавьж, зохисгүй үйлдэл гаргасан тохиолдолд зөрчил гаргасан этгээдийг **зохион байгуулах комисст** мэдэгдэж, асуудлыг шийдвэрлүүлнэ.
8. Түүнчлэн олимпиадад оролцогчид бие биедээ хяналт тавих ба бусад оролцогчийн өмнө дурдсан болон бусад зүй зохисгүй үйлдлийг мэдсэн даруйдаа хянагчид мэдэгдэнэ. Хянагч нь энэ талаар протоколд дэлгэрэнгүй тусгаж, зөрчил гаргасан этгээдийн асуудлыг зохион байгуулах комисст мэдэгдэн шийдвэрлүүлнэ.
9. Олимпиадын үйл ажиллагаа явагдах хугацаанд тухайн сургууль, байгууллагын орчинд оролцогчийн багш эсвэл эцэг эх бусад хамаарал бүхий этгээдийг байлгахгүй.
10. Олимпиадын явцад гарсан дээр дурдсан болон бусад зөрчлийн асуудлыг аймаг, нийслэл, дүүргийн **зохион байгуулах комисс** шийдвэрлэх бөгөөд үүссэн аливаа асуудалд Мэдээлэл зүйл олимпиадын хороо оролцохгүй ба хариуцлага хүлээхгүй.
11. Олимпиадын явцад тооцоолоогүй асуудлаас үүдэн системийн цагийн сунгахыг хүлээх байдал үүссэн үед оролцогчийг утас болон сүлжээнд холбогдох аливаа тоон төхөөрөмжийг ашиглуулахгүй, мөн олимпиад явагдаж буй танхимаас гаргахгүй. Хэрэв оролцогч бодолтоо дууссан гэж үзэж байгаа бол протоколд тэмдэглүүлж, олимпиадыг дуусган явж болно. Энэ тохиолдолд оролцогч уг дэгийн 9 дүгээр заалтыг мөрдөнө.

Монголын мэдээлэл зүйн олимпиадын дэд хороо
(Монголын мэдээлэл зүйн боловсролын тооцоолол нийгэмлэг НҮТББ)

